

Оршин суух зөвшөөрлийн хүчинтэй хугацааг дахин сунгах тухай

Япон улсын Хууль зүйн яамны харьяа Гадаад Иргэн Харьяатын Газраас шинэ төрлийн корона вирусийн халдварт өвчний улмаас хүчинтэй хугацаа нь дууссан Оршин суух зөвшөөрөл (ОСЗ)-ийг доорх зааврын дагуу сунгах болсныг мэдэгдэж байна. Энэхүү сунгалт нь бүх ОСЗ -д хамаарна.

1. 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд олгогдсон ОСЗ-ийн тухайд 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал хүчинтэйд тооцно.

2. 2021 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд олгогдсон ОСЗ-ийн тухайд олгогдсон өдрөөс хойш 6 сарын хугацаанд хүчинтэйд тооцно.

ОСЗ-тэй иргэд визээ мэдүүлэхдээ хүлээн авагч хувь хүн, байгууллагаас “Тухайн виз мэдүүлэгчийг оршин ОСЗ-ийн дагуу хүлээн авахад татгалзах зүйлгүй” гэсэн албан бичиг (он, сар, өдөр, гарын үсэгтэй, маягт харгалзахгүй) авах шаардлагатай бөгөөд энэ нь тухайн ОСЗ-ийг хүчинтэйд тооцох үндэслэл болохыг анхаарна уу.

Жич: Энэхүү албан бичиг нь тухайн иргэн визээ мэдүүлэх өдрийн байдлаар ОСЗ нь олгогдоод 3 сар өнгөрсөн тохиолдолд бүрдүүлнэ.